

## ШУТИС-ИЙН БАГШ, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН МЭДЭЭЛЭЛ

ШУТИС-ийн Ёс зүйн зөвлөлд 2016-2020 онуудад багш, ажилтантай холбоотой ирүүлсэн багш, ажилтантай холбоотой ёс зүйн зөрчлүүд, түүний төрөл, түүнд хүлээлгэсэн хариуцлага, цаашид хийхээр төлөвлөж буй ажлуудын талаар товч мэдээллийг нэгтгэн оруулж байна.

### ШУТИС-ийн багш, ажилтны гаргасан ёс зүйн зөрчлийн тоо (2016-2020)

№	Хичээлийн жил	Хичээлийн жил										Нийт ёс зүйн зөрчил гаргасан хүний тоо
		2016-2017		2017-2018		2018-2019		2019-2020		2020-2021		
		Ёс зүйн зөрчлийн тоо										
		багш	ажилтан	багш	ажилтан	багш	ажилтан	багш	ажилтан	багш	ажилтан	
1	БАС			2	1							3
2	БУХС			1								1
3	ГУУС						1				1	2
4	МХТС											-
5	МехТС											-
6	ҮТС	2	2									4
7	ХШУС	1						1				2
8	ЭХС			2	1							3
9	ГХС											-
10	ДаТС											-
11	Орхон ТС											-
12	БАТС											-
13	Ахлах сургууль											-
14	КООСЭН сургууль	2										2
Дүн		5	2	5	2		1		1		1	17

*ШУТИС-ийн багш, ажилтны гаргасан ёс зүйн зөрчлийн төрөл,  
хариуцлага ногдуулсан байдал (2016-2020)*

№	Хичээлийн жил	Ёс зүйн зөрчил	Ёс зүйн зөвлөлөөс гаргасан шийдвэр	Зөрчлийн тоо
1	2016-2017	Суралцагчидтай ёс зүйгүй харьцаж гутаан доромжилж, сэтгэл зүйн дарамтанд оруулсан	Сануулах	2
2		Оюутнаас мөнгө нэхэж, мөнгө авсан	Хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах	1
3		Бусдын зохиол, бүтээл, судалгааны бүтээлийг хууль бусаар өөрийн болгосон	Сануулах	4
4	2017-2018	Албан тушаалын байдал, эрх мэдлээ ашиглан хувьдаа ашиг хонжоо, давуу тал бий болгосон, багшийн мэргэжлийн ёс зүйн талаар сургуулиас баримталж буй бодлогыг зөрчсөн	Цалинг нь 3 сар хүртэл хугацаагаар 20% бууруулах	1
5		Бусад багш нарыг ажил үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс нөлөөлж, өөрийн үзэл бодлоо тулгах, оюутны үнэлгээг заасан	Сануулах	1
6		Албан тушаал, эрх мэдлээ ашиглан оюутны санал бодол, ухамсарт хүчээр нөлөөлөх, үзэл бодлоо тулгасан	Сануулах	1
7		Албан тушаалын байдал, эрх мэдлээ ашиглан хувьдаа ашиг хонжоо, давуу тал бий болгож, үүрэгт ажлаа хувийн ашиг сонирхолтой хольж хутгасан	Сануулах	1
8		Суралцагчийг үг хэлээр гутаан доромжлох, дорд үзэх, өөрийн давуу байдлаа ашиглан оюутныг бие махбодь, сэтгэл зүйн дарамтанд оруулсан	Сарын цалинг нь 3 сар хүртэл хугацаагаар 20% бууруулах	1
9		Оюутныг үнэлэх явцад оюутантай үл ойлголцол үүссэн	СБЗГ-аас зохицуулалт хийж эвлэрсэн	2
10	2018-2019	Удирдах ажилтныг гүтгэж, хамт олонд ташаа мэдээлэл тараасан	Харъяалах сургууль дээр шийдвэрлэсэн.	1
11	2019-2020	Албан тушаал, эрх мэдлээ ашиглан оюутнаас ном худалдаж авахыг тулгаж, худалдсан, эрх мэдлээ урвуулан ашиглаж тодорхой хүмүүст давуу боломж олгосон.	Сануулах	1
12	2020-2022	Эрх мэдлээ урвуулан ашиглаж тодорхой хүмүүст давуу боломж олгох, боловсон хүчнийг сонгох, дэвшүүлэх зэрэгт өөрийн ойр дотно харилцаатай найз нөхдийг дэмжих, ашиг сонирхлын зөрчил гаргасан.	Харъяалах сургуулиар эхлээд хэлэлцүүлэхээр уламжлуулсан.	1

ШУТИС-ийн багш, ажилтантай холбоотой гарч буй ёс зүйн зөрчлүүдэд дүгнэлт хийсний үндсэн дээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх, багасгах, соён гэгээрүүлэх чиглэлээр дараах ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Багш, ажилтны ёс зүйн асуудлын хүрээнд ёс суртахууны боловсролыг дээшлүүлэх (удирдлагын манлайлал, лидершип, харилцааны ёс зүй, багшийн ёс зүй, ёс зүйн төлөвшилтийн талаар) удирдах ажилтнууд, багш нар, захиргааны болон гүйцэтгэх ажилтнууд, ёс зүйн зөвлөлийн гишүүдэд тусгайлсан цуврал лекц уншуулах, сургалт явуулах;
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад гарч буй багш, ажилтны ёс зүйн зөрчил, асуудал, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох боломж, төрийн албаны болон төрийн үйлчилгээний албан хаагч, судлаачийн ёс зүйн дүрэм, бусад холбогдох эрх зүйн актууд, ёс зүйн дүрмийг сурталчлах хүрээнд “Багш, ажилтны ёс зүйн өдөрлөг, аяны нэгдсэн арга хэмжээ” зохион байгуулах;
- Байгууллагын ёс зүйн зарим стандартыг боловсруулан баталгаажуулж, мөрдүүлэх;
- Ёс зүйн дүрмийн шинэчилж, өөрчлөх, хуульчилсан актуудтай уялдуулах;
- “Байгууллагын соёл, хувь хүний ёс зүйн тухай” мэдээллийг бүрэлдэхүүн сургуулийн болон ШУТИС-ийн цахим хуудсанд оруулах ажлыг тогтмолжуулах.